



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 105

Улаанбаатар  
хот

Улаанбаатар хотын Олон улсын нисэх  
онгоцны шинэ буудлын талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 46.3.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.4, 8.2, Газрын тухай хуулийн 40.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг олон улсын стандартад нийцүүлэн хангаж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулан уг үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг төсвийн тодотголд тусгах замаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.


2. Иргэний нисэхийн ерөнхий газарт нисэх буудлын зориулалтаар Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Тусгай хэрэгцээний газар (Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигийн хөндий Олон улсын нисэх онгоцны буудал)-аас 1200 га газар нэмж эзэмшүүлэхийг Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргалд даалгасугай.

3. Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай хэрэгцээний газрын хилийн зааг”-ийн 7-д заасан “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигийн хөндий (Олон улсын нисэх онгоцны буудал)-ын тусгай хэрэгцээний газартай давхацсан, холбогдох хууль тогтоомж зөрчиж газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон болон газар эзэмших талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, давхцалыг арилгах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт тус тус даалгасугай.

4. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг агаарын замын олон улсын боомт болгох, боомтын зэрэглэл тогтоох асуудлыг боловсруулан 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхийг Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дарга Б.Чойжилсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай.

5. Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийж, шинэ хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгасугай.

6. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах эрчим хүчний дэд станц барьж, шугам сүлжээнд холбох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд П.Ганхүүд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Д.ГАНБАТ